



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2021 оны 12 сарын 09 өдөр

Дугаар 41/228

Шарга

Г Хөрөнгө зарцуулах тухай Г


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Засгийн газрын 2018 оны 318 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн Засаг даргын 2021 оны А/604 дүгээр захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ НЬ.

1. Тус сумын Тосон, Шарга багийн нутагт мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний сэжигтэй тохиолдол илэрч Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн шинжилгээний №22-87 дүгнэлтээр мал, амьтны шүлхий өвчин болох нь тогтоогдсон тул шаардлагатай байгаа хамгаалах хувцас хэрэгсэл, ариутгалын бодисын нөөц бүрдүүлэхэд 5,999,520 (таван сая есөн зуун ерэн есөн мянга таван зуун хорь) төгрөгийг зарцуулсугай.

2. Нийт зардал 5,999,520 (таван сая есөн зуун ерэн есөн мянга таван зуун хорь) төгрөгийг орон нутгийн нөөц хөрөнгөнөөс шийдвэрлэж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Т.Мөнхбаяр), Санхүүгийн албаны дарга (Ш.Эрдэнэцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

3. Нягтлан бодох бүртгэлийн хууль, журмын дагуу санхүүгийн анхан шатны баримтыг бүрдүүлж ажиллахыг Мал эмнэлэгийн тасгийн дарга (Т.Чандмаа), Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Пүрэвжав) нарт үүрэг болгосугай.

ДАРГА



С.ГОНЧИГНЯМ

/Zahiramj 2021/